



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 02 дугаар
Сарын 16-ны өдөр

Дугаар ТҮЗ 2024-02/01

Улаанбаатар
хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.10, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2023 оны тайлант санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, шинээр салбар нээхэд хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг тус тус харгалзан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2023 оны ажлын тайлан, ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай шийдвэр, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (С.Шижиртуяа) нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН